



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 003

Улаанбаатар хот

Г Түр журам батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5, 8.1.13 дахь заалт, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тандалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээг нийслэлд зохион байгуулах түр журам”-ыг нэгдүгээр, Зохион байгуулалтын ерөнхий бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хариу арга хэмжээний багийг хүний нөөц, тоног төхөөрөмж, автомашин, холбогдох төсөв, санхүүгийн хамт нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр шилжүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Л.Баттөр/-д даалгасугай.
3. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын хариу арга хэмжээг бүтцийн дагуу шуурхай зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Б.Бямбадорж/, мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Л.Баттөр/-д тус тус үүрэг болгосугай.
4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн хүнийг бодит хугацааны полимеразын гинжин урвал (бх-ПГУ)-ын шинжилгээ хүлээхгүйгээр эрэмбэлэн ангилж, тусгаарлан, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийг бүх шатны төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д үүрэг болгосугай.



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 14. өдрийн тушаалын
нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТ,
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ НИЙСЛЭЛД ЗОХИОН БАЙГУУЛАХ
TYP ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтыг бууруулах, хүндрэл, нас барагтаас сэргийлэх зорилгоор нийслэлд авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

1.2. Коронавируст халдварт (КОВИД-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг төлөвлөх, хариу арга хэмжээ авах байгууллагуудын гүйцэтгэх үүргийг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Эрүүл мэндийн яамны Хяналт зохицуулалтын бүрэлдэхүүн, үүрэг

2.1. Хяналт, зохицуулалтын багийн бүрэлдэхүүн:

- Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд дарга,
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны албаны дарга,
- Бусад холбогдох ажилтан.

2.2. Нийслэлийн Эрүүл мэндийн газар /НЭМГ/-аас ирүүлсэн нэгдсэн мэдээ, мэдээллийг авах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргагчдыг тогтмол мэдээллээр хангах;

2.3. Нийслэлийн хариу арга хэмжээний багийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, шийдвэр гаргагчдад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Гурав. Халдварт өвчин судлалын үндэсний төв

3.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар нийслэл, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, хариу арга хэмжээний багуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.2. Дүүрэг дэх хариу арга хэмжээний багийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах 2-3 хүний бүрэлдэхүүнтэй багийг дүүрэг бүрт томилон ажиллуулах;

3.3. Лаборатори, тандалт, эмнэлгийн тусlamж, хяналт, халдвараас сэргийлэх, хянах чиглэлээр зөвлөн туслах баг ажиллуулах;

3.4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх эмнэлэг, тусгаарлах байр болон дүүргийн хариу арга хэмжээний

багуудын халдвараас сэргийлэх үйл ажиллагааг мэргэжилтэй арга зүйгээр хангах, зөвлөн туслах;

3.5. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагаас коронавируст халдвар (КОВИД-19)-ын мэдээллийг цуглуулж, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, 7 хоног бүр эргэн мэдээлэл, зөвлөмжөөр хангах;

3.6. Цаашид авах хариу арга хэмжээг нотолгоонд тулгуурлан төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах.

Дөрөв. Нийслэлийн эрүүл мэндийн газар

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт, тусlamж үйлчилгээг нэгдсэн зохицуулалтаар хангах мэргэжлийн багийг дүүрэг бүрт байгуулан ажиллуулах;

4.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажиллах хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах, мэргэжилтнүүдийн судалгааг гаргаж, сургах, хуваарилсан хамгаалах хувцас, хэрэгсэл, бодис, эм, урвалжийн зарцуулалтад хяналт тавих;

4.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа эмнэлгийн орыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг хэвтүүлэн эмчлэхээр дайчлах, үндсэн тусlamжийн зохицуулалтыг шийдвэрлэх;

4.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнийг хэвтүүлэн эмчилж байгаа Эрүүл мэндийн яамны харьяа төрийн өмчийн Эрүүл мэндийн байгууллагын орыг цаашид нэмэгдүүлэх асуудлыг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захирагааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх;

4.5. Нийслэлийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан эмнэл зүйн хөнгөн тохиолдлыг тусгаарлах байрны орны төлөвлөлтийн саналыг хүлээн авч, зохицуулалт хийх;

4.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын талаарх хариу арга хэмжээний багуудын мэдээ, мэдээллийг авч нэгтгэн, ЭМЯ-ны Хяналт зохицуулалтын багт өдөр бүрийн 10 цагт хүргүүлэх;

4.7. Багуудын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

4.8. Хариу арга хэмжээний багийн нөөцийг үнэлэх, бүрдүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулж, сэлгэн ажиллуулах;

4.9. Дүүргийн ачааллаас давсан сорьцыг бусад лабораториудад хуваарилах асуудлыг Эрүүл мэндийн яамны Хяналт зохицуулалтын багтай хамтран зохион байгуулна.

Тав. Дүүргийн хариу арга хэмжээний баг

5.1. Дүүргийн лабораторийн бэлэн байдлыг хангаж, цэгийн болон тандалтын шинжилгээг хийж өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;

5.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн даруйд лабораториос тандалтын багт мэдээлж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

- 5.3. Батлагдсан тохиолдлыг эрэмбэлэн ангилж, холбогдох эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлах байранд хүргэх ажлыг зохион байгуулах;
- 5.4. Эмнэлгийн тусlamжийн баг нь эмнэлгийн орны төлөвлөлтийн саналыг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагад тухай бүр хүргүүлэх;
- 5.5. Хариу арга хэмжээний багийн хувийн хамгаалах хувцас, багаж хэрэгсэл, бодис, эм, урвалжийн нөөцийн судалгааг гарган, бэлэн байдлыг хангах;
- 5.6. Хяналтын баг нь хариу арга хэмжээний багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж шаардлагатай арга хэмжээг тухай бүрт нь зохицуулах.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Эрүүл мэндийн сайдын
2021 оны дүгээр сарын 7-өдрийн
тушаалын хоёрдугаар хавсралт

